



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/829

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 42 дүгээр зүйлийн 42.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай” 7/02 дугаар тогтоолын 12 дугаар, аймгийн Онцгой комиссын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн суурин газрын 2023 оны хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлж үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор орон нутгийн мах, махан бүтээгдэхүүн бэлтгэдэг аж ахуйн нэгжүүдэд орон нутгаас нөөцийн мах бэлтгэн нийлүүлэхэд эргэн төлөх нөхцөлтэй олгох санхүүжилтэд 1200,0 сая төгрөг (нэг тэрбум хоёр зуун сая)-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 1200,0 сая төгрөгийг аймгийн Хөшөөт хөгжил сангийн 2022 оны орлогоос 840,0 төгрөг (найман зуун дөчин сая)-ийг, аймгийн барьцаа дансны үлдэгдлээс 360,0 төгрөг (гурван зуун жаран сая)-ийг тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баярсүх), санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Нөөцийн махны хадгалалт, нийлүүлэлт, чанар, ариун цэврийн стандарт шаардлагад гэрээний дагуу хяналт тавьж үр дүнг дүгнэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (Т.Дэлгэрсайхан), олгосон санхүүжилтийг хугацаандаа татан төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт үүрэг болгосугай.

8400 01 3373

Zah A/829 Am

4. Нөөцийн махны нийлүүлэлтийн гэрээний биелэлтийг хангаж, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаандаа буцаан төвлөрүүлэхийг мах нийлүүлэхээр гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн удирдлагуудад зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

Болормаа Э.Болормаа
Хүндэтгэсэн
2019.08.08

Аймгийн Засаг даргын 2022 оны
12 сарын 23-ны өдрийн А/829 дугаар
захирамжийн хавсралт



АЙМГИЙН 2023 ОНЫ НӨӨЦИЙН МАХ БЭЛТГЭХ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

ДД	Нийлүүлэгчийн нэр	Мах нийлүүлэх тоо хэмжээ /тн/	Олгох санхүүжилт	Үүнээс	
				Барьцаа хөрөнгийн данснаас	
				2022.12.26	2023.01.15
1	"ИОВ" ХХК Р-4066901	25.57	200000.0	140000.0	60000.0
2	"Баруун монгол интернэйшнль" ХХК Р-2033763	25.57	200000.0	140000.0	60000.0
3	"Ирмүүн чандмань" ХХК Р-4078748	25.57	200000.0	140000.0	60000.0
4	"Жаргалант шанд" ХХК Р-4070348	25.57	200000.0	140000.0	60000.0
5	"ХАН Жаргалант Ховд" хоршоо Р-2381419	25.57	200000.0	140000.0	60000.0
6	"Алтайн мийт" ХХК Р-4092201	25.57	200000.0	140000.0	60000.0
	Нийт дүн	153.0	1200000.0	840000.0	360000.0

-oOo-